

CAR ZEEL АППЛИКЕЙШНИЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ

ТА ҮЙЛЧИЛГЭЭГ АВАХЫН ӨМНӨ ЭНЭХҮҮ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛТЭЙ БҮРЭН ТАНИЛЦАЖ, ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ЭСЭХИЙГ ХАРААТ БУСААР, БИЕ ДААН ШИЙДВЭРЛЭХИЙГ ЗӨВЛӨЖ БАЙНА.

Энэхүү Үйлчилгээний нөхцөл нь Монгол Улсын Иргэний хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Банк бас санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан холбогдох дүрэм, журам болон бусад хууль тогтоомжид үндэслэсэн бөгөөд Монгол Улсад бүртгэлтэй "Мандал Дижитал Кредит" ББСБ ХХК (цаашид "ББСБ" гэх) болон иргэн (цаашид "Хэрэглэгч" гэх)-ийн хооронд Car Zeel аппликейшн (цаашид "Апп" эсхүл "Аппликейшн" гэх)-ээр дамжуулан зээлийн үйлчилгээ авах, үзүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулах бөгөөд Хэрэглэгчийн хувийн болон санхүүгийн мэдээллийг хүлээн авах, цуглуулах, ашиглах, боловсруулах, хадгалах, дамжуулах, зээлийн гэрээ байгуулах, зээл олгох, эргэн төлүүлэх зэрэг харилцаанд мөрдөгдөх эрх, үүргийг тодорхойлсон, талуудад эрх зүйн үр дагавар үүсгэх хүчин төгөлдөр хэлцэл болно.

Нэг. Ерөнхий зүйл

1.1. ББСБ нь Үйлчилгээг илүү боловсронгуй болгох зорилгоор Үйлчилгээний нөхцөлд өөрчлөлт оруулах эрхийг дангаар эдлэх бөгөөд уг өөрчлөлтийн талаар Хэрэглэгчийн бүртгүүлсэн Аппликейшнээр дамжуулан Хэрэглэгчид мэдэгдэнэ.

1.2. Хэрэглэгч нь өөрчлөлтийн талаарх мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 10 (арав) өдрийн дотор уг өөрчлөлтийг эс зөвшөөрч байгаагаа ББСБ-д мэдэгдээгүй бол өөрчлөлтийг бүрэн хүлээн зөвшөөрсөнд тооцож, шинэчилсэн Үйлчилгээний нөхцөл хүчин төгөлдөр үйлчилнэ.

Хэрэглэгч өөрчлөлтийг хүлээн зөвшөөрөхөөс татгалзсан тохиолдолд өөрчлөлт хүчин төгөлдөр болохоос өмнө байгуулсан зээлийн гэрээний хүрээнд үүссэн эрх, үүрэг нь тухайн гэрээний нөхцөлийн дагуу үргэлжлэн хэрэгжинэ. Мөн хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Аппликейшнээр дамжуулан шинээр зээлийн хүсэлт гаргах, шинэ зээлийн үйлчилгээ авах, бусад үйлчилгээг ашиглах боломжгүй байна.

1.3. Үйлчилгээний нөхцөлд хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

- "ББСБ" гэж Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаа эрхэлж буй "Мандал Дижитал Кредит" ББСБ ХХК-ийг;
- "Апп" эсхүл "Аппликейшн" гэж Хэрэглэгчийн ухаалаг гар утас, бусад төхөөрөмжид татан авч, ББСБ-ын санал болгож буй зээлийн үйлчилгээнээс сонгон авах зориулалт бүхий Car Zeel нэртэй аппликейшнийг;
- "Хэрэглэгч" гэж Аппликейшнийг татаж, өөрийн мэдээллээ бүртгүүлж, баталгаажуулан, ББСБ-ын дотоод дүрэм, журмын шаардлага хангасан, Монгол Улсын иргэн, 18 насанд хүрсэн, эрх зүйн бүрэн чадамжтай этгээдийг;
- "КҮС / Харилцагчийг таньж мэдэх" гэж Хэрэглэгчийг таньж, баталгаажуулах зорилгоор Хэрэглэгчийн бичиг баримт, зураг, мэдээллийг цуглуулж шалгах үйл ажиллагааг;

- "Биометрик мэдээлэл" гэж Хэрэглэгчийг таньж баталгаажуулах, залилан болон бусад эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор ашиглаж буй Хэрэглэгчийн нүүр царайны бодит цагийн дүрс мэдээллийг хэлэх бөгөөд уг мэдээллийг Хэрэглэгчийн иргэний үнэмлэх, ХУР системээс татуулсан зурагтай харьцуулан баталгаажуулна;
- "Скоринг" гэж Хэрэглэгчийн санхүүгийн болон хувийн мэдээлэл, зээлжих зэрэглэлийн оноонд үндэслэн ББСБ-ын аргачлалын дагуу зээлийн эргэн төлөлтийн чадварыг тодорхойлох үнэлгээг;
- "Дижитал зээлийн эрхийн гэрээ" гэж Хэрэглэгч энэхүү Үйлчилгээний нөхцөлийг зөвшөөрч, Аппликейшнээр зээлийн хүсэлт гаргасныг ББСБ хүлээн зөвшөөрсний үндсэн дээр цахимаар байгуулагдах, талуудын эрх, үүргийг тодорхойлсон гэрээг;
- "Контент" гэж аппликейшн дээрх мэдээлэл, өгөгдөл, технологийн хэрэгсэл, код, хэв загвар, аппликейшн, санаа, ноу-хау, лого, бичвэр, дүрс, зураг, бичлэг, дизайн, бүтээгдэхүүн, үйлчилгээ, шийдэл, шаардлага, сурталчилгааны материал болон тэдгээрт хэвлэгдсэн бүх төрлийн бичгийн болон мультимедиа материал зэрэг бүх контент хамаарна;
- "Баталгаажуулах код" гэж Хэрэглэгчийн бүртгүүлсэн гар утасны дугаар болон и-мэйл хаягт илгээгдэх, Хэрэглэгчийг баталгаажуулах зориулалт бүхий нэг удаагийн кодыг ойлгоно.

Хоёр. Зээлийн үйлчилгээний нөхцөл

2.1. ББСБ Хэрэглэгчид дараах ерөнхий нөхцөлөөр зээлийн үйлчилгээ үзүүлнэ:

- Зээлийн дүн: 300,000 (гурван зуун мянга) - 5,000,000 (таван сая) төгрөг;
- Зээлийн хугацаа: хуанлийн 7, 14, 21, 30 хоног;
- Зээлийн хүү (сарын): 4.5% (дөрөв аравны тав) хувь.
- Шимтгэл: 1% /нэг/ хувь

2.2. ББСБ нь Хэрэглэгчийн ирүүлсэн зээлийн хүсэлт, хувийн болон санхүүгийн мэдээлэлд үндэслэн КҮС болон Скоринг хийж, Хэрэглэгчид олгох боломжтой зээлийн хэмжээ, хугацаа болон бусад нөхцөлийг тодорхойлно. Хэрэглэгч шинээр зээлийн хүсэлт гаргах бүрд ББСБ нь тухайн үеийн мэдээлэлд үндэслэн Скоринг үнэлгээг дахин хийж, зээлийн нөхцөлийг тухай бүр шинээр тогтооно.

2.3. Нэг удаагийн Скоринг үнэлгээгээр тогтоосон зээлийн эрх нь 12 (арван хоёр) цагийн хугацаанд хүчинтэй байх бөгөөд уг хугацаа дууссан тохиолдолд Хэрэглэгч зээлийн эрхээ дахин тогтоолгох шаардлагатай.

2.4. ББСБ нь зах зээлийн нөхцөл, хууль тогтоомжийн өөрчлөлт, дотоод бодлогоос хамааран зээлийн дүн, хугацаа, хүүгийн хэмжээнд өөрчлөлт оруулах эрхтэй бөгөөд энэ тухай Хэрэглэгчид Аппликейшнээр урьдчилан мэдэгдэнэ.

2.5. Хэрэглэгч Зээлийн гэрээгээр хүлээсэн эргэн төлөлтийн үүргээ гэрээнд заасан хуваарийн дагуу, хугацаанд нь бүрэн биелүүлэх үүрэгтэй.

Гурав. Мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах эрх

3.1. Хэрэглэгч энэхүү Үйлчилгээний нөхцөлийг зөвшөөрснөөр ББСБ-д дараах эрх, зөвшөөрлийг олгоно:

- Хэрэглэгчийн үүсгэсэн, дамжуулсан хувийн болон санхүүгийн мэдээллийг хүлээн авах, хадгалах;
- Хэрэглэгчийн мэдээлэлд хиймэл оюун ухааны тусламжтайгаар дүн шинжилгээ хийх, тэдгээрийн үнэн зөвийг шалгаж баталгаажуулах;
- Хэрэглэгчийн авах боломжтой зээлийн хэмжээ, нөхцөлийг тодорхойлох, зээл олгохоор шийдвэрлэсэн тохиолдолд Зээлийн гэрээний төслийг боловсруулахад ашиглах;
- Үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх зорилгоор дотоод хэрэгцээнд ашиглах, Аппликейшн болон түүний хиймэл оюун ухааныг хөгжүүлэхэд ашиглах;

3.2. Хэрэглэгчийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, дамжуулах дэлгэрэнгүй нөхцөлийг ББСБ-ын Нууцлалын бодлогоор зохицуулна.

Дөрөв. Хэрэглэгчийн эрх, үүрэг

4.1. Хэрэглэгч Аппликейшинд хувийн болон санхүүгийн мэдээллээ оруулахдаа дараах үүргийг хүлээнэ:

- Хуурамч мэдээлэл оруулахгүй байх;
- Бусдын хувийн болон санхүүгийн мэдээлэл оруулахгүй байх;
- Хувийн болон эмзэг мэдээллээ аюулгүй хамгаалах;
- Нэвтрэх нэр болон нууц үг, пин код зэрэг мэдээллийг хамгаалах үүргээ биелүүлээгүй, санаатайгаар шилжүүлсэн, алдсан, зарцуулсан, гуравдагч этгээд ашигласан тохиолдолд ББСБ хариуцлага хүлээхгүй ба өр төлбөр, хураамж, нэмэгдүүлсэн хүү, зээлийн мэдээллийн ангилал буурах, эрх хязгаарлах зэргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй;
- Хэрэглэгч нь гүйлгээ хийхдээ дансны дугаар, гүйлгээний утга, гүйлгээний дүнгээ зөв оруулах бөгөөд буруу оруулсны улмаас үүсэх зардал, аливаа хохирлыг өөрөө хариуцна.
- Зээлийн гэрээгээр хүлээсэн төлбөр төлөх үүргээ гэрээнд заасан хугацаанд бүрэн биелүүлэх.

4.2. Хэрэглэгч дараах эрхийг эдэлнэ:

-  Өөрийн хувийн мэдээлэлтэй танилцах, засварлуулах, шаардлагатай тохиолдолд устгуулах эрх;
- Зээлийн нөхцөл, хүү, төлбөрийн хуваарийн талаар ББСБ-аас бүрэн мэдээлэл авах эрх;
- Үйлчилгээтэй холбоотой гомдол, санал, хүсэлтээ ББСБ-д гаргах эрх;
- Бүртгэлээ идэвхгүй болгуулах хүсэлт гаргах эрх.

4.3. Хэрэглэгч Үйлчилгээний нөхцөлийн 4.1-д заасныг зөрчиж хуурамч мэдээлэл оруулсан, бусдын нэр, хувийн болон санхүүгийн мэдээллийг ашигласан, эсхүл дамжуулсан тохиолдолд ББСБ нь Хэрэглэгчийн зээлийн хүсэлтийг хянаад Зээлийн гэрээ байгуулахаас татгалзах эрхтэй. Хэрэглэгч өөрийн хууль бус үйлдлийн улмаас тухайн мэдээллийн өмчлөгч, эзэмшигч болон ББСБ-д учруулсан аливаа гэм хор, хохирлыг бүрэн хариуцна.

Тав. ББСБ-ын эрх, үүрэг

5.1. ББСБ дараах эрх эдэлнэ:

- Хэрэглэгчийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах, Аппликейшнийг зүй бусаар, хууль бус зорилгоор ашиглахаас урьдчилан сэргийлэх зорилгоор Хэрэглэгчийн хандалт, үйлдлийн түүхийг хадгалах, хуулийн хүрээнд ашиглах;
- Хэрэглэгчийн хувийн мэдээллийн өөрчлөлтийг эрх бүхий байгууллагаас гаргуулан авах;
- Хэрэглэгчийг хууль тогтоомж, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах, шаардлагыг хангаагүй тохиолдолд гэрээг цуцлах.

5.2. ББСБ нь дараах тохиолдолд Хэрэглэгчид урьдчилан сануулалгүйгээр зээлжих эрхийг түр хаах, шаардлагатай бол Зээлийн гэрээг дуусгавар болгох эрхтэй. Үүнд Хэрэглэгч:

- Гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа зөрчсөн;
- Зээлийг хууль бус үйл ажиллагаанд ашигласан;
- Худал мэдээлэл өгсөн;
- Хууран мэхэлсэн;
- ББСБ-ын үйл ажиллагаанд саад учруулсан;
- Car Zeel зээлийн үйлчилгээг бусад хэрэглэгчдэд хортой, зүй зохисгүй байдлаар ашигласан;
- Эрх зүйн чадвар дуусгавар болсон;
- Хууль, хяналтын байгууллагаас ирсэн мэдэгдлийг үндэслэн зээлийн эрхийг хаах шаардлагатай болсон.

5.3. ББСБ Хэрэглэгчийн оруулсан хувийн болон санхүүгийн мэдээллийг энэхүү Үйлчилгээний нөхцөл болон Нууцлалын бодлогод зааснаас бусад зорилгоор ашиглахгүй, бусад задруулахгүй байх, мэдээллийн нууцлалыг хамгаалах үүрэгтэй.

Зургаа. Төлбөр төлөлт, хугацаа хэтрэлт, нэмэгдүүлсэн хүү

6.1. Хэрэглэгч Зээлийн гэрээнд заасан төлбөрийг хуваарийн дагуу хугацаанд нь бүрэн төлж барагдуулах үүрэг хүлээнэ.

6.2. Хэрэглэгч төлбөрөө гэрээнд заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд “Зээлийн гэрээ”-ний дагуу нэмэгдүүлсэн хүү бодно

6.3. Нэмэгдүүлсэн хүүгийн нийт дүн нь холбогдох хууль тогтоомжид заасан дээд хязгаараас хэтрэхгүй байна.

6.4. Хэрэглэгч төлбөрийн хугацааг хэтрүүлсэн тохиолдолд ББСБ нь хугацаа хэтэрсэн төлбөрийг бүрэн барагдуулах хүртэл хугацаанд Хэрэглэгчийн шинээр зээл авах эрхийг түр зогсоох эрхтэй.

6.5. Хэрэглэгч төлбөр төлөх хугацаагаа хэтрүүлсэн тохиолдолд ББСБ нь холбогдох хууль, журамд заасны дагуу Хэрэглэгчийн мэдээллийг Зээлийн мэдээллийн санд ангилал бууруулан нийлүүлэх эрхтэй бөгөөд Хэрэглэгч уг бүртгэлтэй холбоотой маргаан гаргахгүй.

6.6. Хэрэглэгч зээлийн төлбөрийг хугацаанд нь төлөөгүй, эсхүл төлбөрийн үүргээ удаа дараа бүрэн биелүүлээгүй тохиолдолд ББСБ нь холбогдох хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу өр төлбөрийг албадан гаргуулах зорилгоор шүүх болон бусад эрх бүхий байгууллагад хандах эрхтэй.

Долоо. Хэрэглэгчийн мэдээллийн нууцлал

7.1. ББСБ Хэрэглэгчийн оруулсан хувийн болон санхүүгийн мэдээллийг энэхүү Үйлчилгээний нөхцөлд зааснаас бусад зорилгоор ашиглахгүй, бусдад задруулахгүй байх, мэдээллийн нууцлалыг хамгаалах үүрэгтэй.

7.2. Аппликейшний программ хангамж нь Хэрэглэгчийн үндсэн мэдээлэл, зээлийн болон эргэн төлөлтийн талаарх мэдээллийг автоматаар серверт архивлан хадгалах ба цаасан баримтыг архивд хадгална.

7.3. Аппликейшний программ хангамж, систем нь Хэрэглэгчийн мэдээллийн нууцлалыг хамгаалахуйц техникийн нөхцөлийг бүрэн хангасан байна.

7.4. Хэрэглэгчийн зөвшөөрлийн дагуу цуглуулсан мэдээллийг энэхүү Үйлчилгээний нөхцөлийн Гурав, Тав дугаар бүлэгт зааснаас өөрөөр ашиглах, хамааралгүй гуравдагч этгээдэд задруулахыг хориглоно.

7.5. Хэрэглэгч нэвтрэх нууц үг, гүйлгээний нууц код зэргийг үрэгдүүлсэн, хулгайд алдсан, эрх олгогдоогүй шилжүүлэг хийгдсэн тухай мэдсэн, эсхүл бусад зөрчил илэрсэн тохиолдолд нэн даруй нууц үгээ солих, ББСБ-д мэдэгдэх үүрэгтэй. Энэхүү үүргээ биелүүлээгүйгээс, эсхүл хугацаа алдсаны улмаас үүссэн хохирлыг Хэрэглэгч бүрэн хариуцна.

7.6. Хэрэглэгчийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас ББСБ нь өр төлбөрийг барагдуулах, шаардах эрхээ хэрэгжүүлэх, шүүх болон албадан гүйцэтгэх ажиллагаанд хандахтай холбоотойгоор хууль тогтоомжид нийцүүлэн гарсан шүүхийн зардал, улсын тэмдэгтийн хураамж, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардал болон бусад холбогдох зардлыг Хэрэглэгч хариуцна.

7.7. Хэрэглэгчийн ДАН (Дан систем)-аар баталгаажсан мэдээллийг устгах, солих боломжгүй.

7.8. Үйлчилгээ авахаас өмнө татгалзсан Хэрэглэгч бүртгэлээ идэвхгүй болгох хүсэлтийг бичгээр гаргасан тохиолдолд ББСБ ажлын 10 хоногт багтаан Хэрэглэгчийг идэвхгүй төлөвт оруулна.

Найм. Үйлчилгээний эрсдэл, хариуцлагын хязгаарлалт

8.1. ББСБ-ын систем, программаас үүдэлтэй доголдол гарснаас зээл олгох, эргэн төлөлт хийхэд саад учирсан тохиолдолд Хэрэглэгч энэ талаар холбогдох сувгаар ББСБ-д нэн даруй мэдэгдэж, гомдол гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Тухайн гомдлыг хуанлийн 30 хоногт багтаан хянан шийдвэрлэж, Хэрэглэгчид хариу мэдэгдэнэ.

8.2. Хэрэглэгч Аппликейшнд нэвтрэх нэр, нууц үг, баталгаажуулах код болон бусад нэвтрэх мэдээллийг бусдад задруулсан, алдсан, эсхүл өөрийн хайхрамжгүй үйлдэл, эс үйлдэхүйн улмаас гуравдагч этгээд ашигласан тохиолдолд үүнээс үүсэх аливаа хохирол, эрсдэлийг Хэрэглэгч өөрөө бүрэн хариуцна.

8.3. ББСБ нь өөрийн буруутай үйлдлээс шалтгаалан Хэрэглэгчид бодит хохирол учирсан нь хууль ёсны баримтаар нотлогдсон тохиолдолд ББСБ-ын хариуцлага нь зөвхөн тухайн зээлийн гэрээний дүнгийн хүрээнд хязгаарлагдах бөгөөд шууд бус, дам болон алдагдсан ашигтай холбоотой аливаа хохирлыг ББСБ хариуцахгүй.

8.4. Хэрэглэгч энэхүү Үйлчилгээний нөхцөлийг зөвшөөрч, Аппликейшнийг ашигласан нь Хэрэглэгч болон ББСБ-ын хооронд Зээлийн гэрээ байгуулагдсан, эсхүл ББСБ нь Хэрэглэгчид зээл олгох амлалт өгсөн гэж үзэх үндэслэл болохгүй бөгөөд энэхүү Үйлчилгээний нөхцөл нь тусгайлан дурдсанаас бусад асуудлаар ББСБ-ын эсрэг шаардлага гаргах эрхийг Хэрэглэгчид олгохгүй.

Ес. Гуравдагч этгээдийн холбоос

9.1. Аппликейшн нь ББСБ-тай хамтран ажилладаг гуравдагч этгээдийн вэбсайт, үйлчилгээ рүү шилжих холбоосыг агуулж болох бөгөөд эдгээр нь ББСБ-ын хяналтаас гадуур байх тул тэдгээр гуравдагч талын контенттой холбоотойгоор ББСБ хариуцлага хүлээхгүй.

Арав. Үйлчилгээний оюуны өмчийн хамгаалалт

10.1. Хэрэглэгч Аппликейшн доторх контент (программ хангамж, код, лого, дизайн, санаа зэрэг)-ийг ББСБ-ын зөвшөөрөлгүйгээр өөрчлөх, хуулбарлах, худалдах, түгээх, дамжуулах эсхүл бусад хэлбэрээр зүй зохисгүй ашиглахыг хориглоно.

10.2. Энэхүү Үйлчилгээний нөхцөлийн дагуу Аппликейшнийг ашиглахаас бусад тохиолдолд Хэрэглэгч контент (программ хангамж, код, лого, дизайн, санаа зэрэг) -д хамаарах аливаа эрх эдлэхгүй.

Арван нэг. Бүртгэл идэвхгүй болгох, гомдол шийдвэрлэх, холбоо барих

11.1. Хэрэглэгч нь бүртгэлээ идэвхгүй болгох хүсэлт, түүнчлэн Үйлчилгээтэй холбоотой санал, хүсэлт, гомдол болон бусад асуудлаар дараах сувгаар ББСБ-д хандаж болно:

- И-мэйл: info@mandalcredit.mn
- Утас: 76001661 (Даваа - Баасан, 09:00 цаг - 18:00 цаг)

Арван хоёр. Хүчин төгөлдөр болох

12.1. Хэрэглэгч Аппликейшнд бүртгүүлсэн гар утасны дугаарт илгээсэн Баталгаажуулах кодыг "БАТАЛГААЖУУЛАХ КОД" хэсэгт оруулан "БАТАЛГААЖУУЛАХ" товчлуурыг дарснаар энэхүү Үйлчилгээний нөхцөлийг бүрэн ухамсарлаж, ойлгож, хүлээн зөвшөөрснөөр тус хэлцэл хүчин төгөлдөр болно.

12.2. Хэрэглэгч Үйлчилгээний нөхцөлийг зөвшөөрөхгүй байгаа бол "Татгалзах" товчийг дарж системээс гарна. Энэ тохиолдолд ББСБ-ын Car Zeel зээлийн аппликейшнийг ашиглах боломжгүй болохыг анхаарна уу.

-МАНДАЛ ДИЖИТАЛ КРЕДИТ ББСБ ХХК-